

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/34/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> СНАГ-ын аудитын менежер: С.Нацагдорж Утас:261885 Цахим хаяг: <a href="mailto:Natsagdorjs@audit.gov.mn">Natsagdorjs@audit.gov.mn</a> СНАГ-ын ахлах аудитор: Б.Эрдэнэзул Утас: 261729 Цахим хаяг: <a href="mailto:erdenezulb@audit.gov.mn">erdenezulb@audit.gov.mn</a> СНАГ-ын ахлах аудитор: Ж.Энхтуяа Утас: 260512 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyaj@audit.gov.mn">enkhtuyaj@audit.gov.mn</a> СНАГ-ын аудитор: М.Лхагвасүрэн Утас:260512 Цахим хаяг: <a href="mailto:lkhagvasuren@audit.gov.mn">lkhagvasuren@audit.gov.mn</a> СНАГ-ын аудитор: Д.Эрдэнэчимэг Утас:260512 Цахим хаяг: <a href="mailto:Erdenechimegda@audit.gov.mn">Erdenechimegda@audit.gov.mn</a> СНАГ-ын аудитор: Н.Нямсүрэн Утас:260512 Цахим хаяг: <a href="mailto:Nyamsuren@audit.gov.mn">Nyamsuren@audit.gov.mn</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 840  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ГЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН  
ЗАСГИЙН ГАЗРЫН ОНЦГОЙ БҮРЭН  
ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ Ж.ГАНБАТ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн онцгой бүрэн эрхт төлөөлөгч Засгийн газрын 2022 оны 362, 385 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд нүүрс олборлолт, тээвэрлэлтийг зохион байгуулж, борлуулалт, экспортыг нэмэгдүүлэх, нүүрсийг хил нөхцөлтэй биржээр арилжих чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлснээр өмнөх оноос нүүрс олборлолтыг 3.2 дахин, нүүрс тээврийг 3.6 дахин, нүүрс борлуулалтыг 4.1 дахин нэмэгдүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Эргэлтийн бус хөрөнгөнд бүртгэлтэй 2017 оноос 2023 онд үүссэн Эрдэнэс Монгол ХХК-ийн харьяа нэр бүхий 5 байгууллагын 10-аас дээш жилийн эргэн төлөх хугацаатай нийт 2,778,695.2 сая төгрөгийн урт хугацаат авлагын үлдэгдэлд 807,250.7 сая төгрөгийн үнэ цэний бууралт тооцсон байна.

Эрдэнэс Тавантолгой ХК нь 2021 оноос 2024 онд компанийн ашиг, орлогыг нэмэгдүүлэх төслүүдийг санхүүжүүлэхээр бондын эх үүсвэрээр нийт 620,045.6 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Транч-1 болон 4-ийн үндсэн төлбөрийг хүүгийн хамт

Z:\Yewsan\_Bichig\2024\0325 SNAG-49.Docx

0001030358

барагдуулж, тайлант оны санхүүгийн тайлангаар транч-2 болон 3 боңдын үндсэн төлбөрт 306,875.7 сая төгрөг, хүүгийн төлбөрт 7,802.6 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Тус компани 2017 оны 7 дугаар сард Чингис хаан банктай "Харилцах дансны үйлчилгээний гэрээ" байгуулан валютын харилцах данс нээн хамтран ажилласан боловч 2019 оны 4 дүгээр улирлаас банк гэрээний үүргээ биелүүлээгүй, гүйлгээ хийхэд саад учруулж эхэлсэн байна. Чингис хаан банкны дансанд байршуулсан мөнгөө төлүүлэхээр шүүхэд хандан Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албадан гүйцэтгэх захирамжийн дагуу 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн гүйцэтгэх хуудсаар 53,266.3 сая төгрөгийг албадан гүйцэтгэхээр шийдвэрлэсэн боловч одоо хүртэл хэрэгжээгүй хэвээр байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 11,124,212.6 сая төгрөгийн орлого олж, 7,506,241.4 сая төгрөгийн зардал гарган, 3,617,971.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөсөн байна.

Нийт орлогын гүйцэтгэл 9,683,145.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,441,067.2 сая төгрөг буюу 13.0 хувиар тасарсан нь БНХАУ-ын зах зээлд 2023 оны 2, 3 дугаар улирлуудад нүүрсний үнэ төлөвлөснөөс бага байсан нь нөлөөлжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 4,650,976.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,650,473.9 сая төгрөгийн хэмнэлттэй байна. Энэ нь уулын ажлын хөрс хуулалтын төлөвлөгөөний биелэлт 59.0 хувь болсноор борлуулсан бүтээгдэхүүний өртөг 482,933.2 сая төгрөгийн дутуу зарцуулалттай, хүргэж өгөх нөхцөлтэй тээвэр, ачилт, буулгалтын зардал 986,220.3 сая төгрөгөөр хэмнэгдсэн зэрэг нь гол нөлөө үзүүлсэн.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 59 зорилтын хүрээнд 236 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 83.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн А/103 дугаар тушаалаар "Уурхайн нүүрсний агуулахын менежментийн журам"-ыг шинэчлэн батлуулж Цанхийн уурхайн агуулахад хадгалагдаж буй нийт нүүрсний овоолгуудын дугаарлалтыг дахин давтагдахгүй байдлаар шинэчлэн дугаарлаж нэршил өөрчилсөн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Z:\Yawsan\_Bicrigl\2024\0325 SNAG-49.Docx

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д ЗАГДЖАВ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

#### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	385,342,017,234.58	1,564,192,921,300.34
1.1.2	Дансны авлага	30,764,019,234.60	550,665,114,196.67
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	3,470,861,988.97	18,122,595,802.18
1.1.4	Бусад авлага	983,779,713.02	64,782,050,738.85
1.1.6	Бараа материал	393,822,406,140.33	366,734,620,712.47
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,711,231,693,184.54	2,155,005,031,490.95
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,525,614,777,496.04</b>	<b>4,719,502,334,241.46</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	232,654,639,072.82	1,232,751,118,355.41
1.2.2	Биет бус хөрөнгө	11,108,033,528,155.09	11,063,983,254,443.70
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,346,763,751,000.00	1,346,763,751,000.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	18,529,089,419.64	18,783,644,399.63
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	117,625,024,693.74	121,646,587,139.31
1.2.6	Бусад эргэлтийн бус хөрөнгө	2,131,168,104,919.17	2,396,180,912,636.39
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>14,954,774,137,260.46</b>	<b>16,180,109,267,974.44</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>17,480,388,914,756.50</b>	<b>20,899,611,602,215.90</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	162,654,229,673.74	162,741,152,109.28
2.1.1.2	Цалингийн өглөг	5,845,713,567.24	6,601,970,702.94
2.1.1.3	Татварын өр	472,670,076,432.95	710,401,949,735.20
2.1.1.4	НДШ–ийн өглөг	365,730,569.12	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	411,661,385,600.00	306,875,700,000.00
2.1.1.6	Хүүгийн өглөг	18,061,974,596.80	7,802,577,122.80
2.1.1.7	Урьдчилж орсон орлого	1,445,589,508,604.85	1,671,694,661,445.35
2.1.1.8	Нөөц /өр төлбөр/	3,634,141,463.68	-
2.1.1.9	Бусад богино хугацаат өр төлбөр	2,817,769,320.00	2,817,769,320.00
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,523,300,529,828.38</b>	<b>2,868,935,780,435.57</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/ УХ	249,816,291,425.20	173,827,288,075.96
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	6,683,214,480.97	6,683,214,480.97
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	1,146,482,599,600.00	762,988,699,600.00
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,402,982,105,506.17</b>	<b>943,499,202,156.93</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>3,926,282,635,334.55</b>	<b>3,812,434,982,592.50</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:- төрийн		
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат	11,196,000,000,000.00	11,196,000,000,000.00
2.3.4	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	2,358,106,279,421.95	5,891,176,619,623.40
<b>2.3.5</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>13,554,106,279,421.95</b>	<b>17,087,176,619,623.40</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>17,480,388,914,756.50</b>	<b>20,899,611,602,215.90</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,494,471,945,664.14	9,547,902,886,462.14
2	Борлуулалтын өртөг	708,909,356,579.18	2,153,348,581,516.28
3	Нийт ашиг( алдагдал)	2,785,562,589,084.96	7,394,554,304,945.86
4	Түрээсийн орлого	180,768,854.72	229,845,018.75
5	Хүүгийн орлого	1,978,633,122.28	20,565,532,101.92
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	104,867,528,950.44	114,447,142,052.75
9	Борлуулалт, маркетингийн зардал	807,266,583,896.36	2,223,690,324,291.44
10	Ерөнхий ба удирдлагын зардал	23,478,122,372.36	187,552,560,444.33
11	Санхүүгийн зардал	101,629,529,736.00	75,181,003,524.24
12	Бусад зардал	158,836,995,514.51	255,902,958,282.64
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(12,353,863,742.86)	( 39,160,583,138.28)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(72,526,303.74)	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,788,951,898,446.57	4,748,309,394,438.35
19	Орлогын татварын зардал	484,460,557,193.88	1,220,583,453,926.13
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,304,491,341,252.69	3,527,725,940,512.22
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,304,491,341,252.69	3,527,725,940,512.22
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Бусад олз (гарз)	-	-
25	Орлогын нийт дүн	3,601,498,876,591.58	9,683,145,405,635.56
26	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	108.71	293.98

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>11,196,000,000,000.00</b>	<b>1,060,831,522,970.97</b>	<b>12,256,831,522,970.90</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(7,216,584,801.71)	(7,216,584,801.71)
3	Залруулсан үлдэгдэл	-	1,053,614,938,169.26	12,249,614,938,169.20
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	1,304,491,341,252.69	1,304,491,341,252.69
9	<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>11,196,000,000,000.00</b>	<b>2,358,106,279,421.95</b>	<b>13,554,106,279,421.95</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	5,344,399,689.23	5,344,399,689.23
11	Залруулсан үлдэгдэл	11,196,000,000,000.00	2,363,450,679,111.18	13,559,450,679,111.10
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	3,527,725,940,512.22	3,527,725,940,512.22
17	<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>11,196,000,000,000.00</b>	<b>5,891,176,619,623.40</b>	<b>17,087,176,619,623.40</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,447,794,283,520.27	7,509,699,726,615.75
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,307,284,802,521.72	7,448,250,568,240.78
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	48,038,999.91	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	140,461,441,998.64	61,449,158,374.97
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,032,625,411,796.56	5,141,078,196,770.92
1.2.1	Ажиллагчдад төлсөн	70,514,844,104.53	126,975,452,536.38
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	16,600,000,000.00	31,580,510,917.46
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	850,215,782,900.17	1,753,713,622,769.50
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	41,034,139.49	57,703,874.05
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	28,096,638,682.37	43,399,024,480.92
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	72,253,244,444.57	60,530,745,736.10
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	990,880,298,093.14	2,789,573,165,155.13
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,222,792,399.94	1,140,970,188.10
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,800,777,032.35	334,107,001,113.28
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,415,168,871,723.71	2,368,621,529,844.83
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,618,640,793.57	10,930,778,760.70
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	1,618,640,793.57	10,930,778,760.70
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,042,700,832,068.51	690,799,709,687.77
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	40,505,354,371.72	111,869,457,337.60
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,121,251,873.44	710,695,187.50
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	1,001,074,225,823.35	578,219,557,162.67
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,041,082,191,274.94)	(679,868,930,927.07)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	146,491,779,470.00	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	146,491,779,470.00	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	201,235,158,622.38	490,990,884,718.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	201,235,158,622.38	490,990,884,718.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(54,743,379,152.38)	(490,990,884,718.00)
4	Валютын ханшийн зөрүү	16,816,560,693.67	(18,910,810,134.00)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	336,159,861,990.06	1,178,850,904,065.76

6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	49,182,155,244.52	385,342,017,234.58
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	385,342,017,234.58	1,564,192,921,300.34

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/ мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Жилийн төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Хувь
А	Б	В	1	2	3	4
<b>1</b>	<b>Олборлолт, борлуулалт</b>					
	Борлуулах нүүрсний хэмжээ	мян.тн	30,003.9	29,303.3	(700.6)	97.7
	Борлуулах нүүрсний жинлэсэн дундаж үнэ	\$/тонн	105.9	95.3	(10.6)	90.0
	<b>Уурхайн ам нөхцөл</b>	<b>\$/тонн</b>	<b>94.7</b>	<b>90.7</b>	<b>(4.0)</b>	<b>95.8</b>
	Хатуу коксжих нүүрс	\$/тонн	103.3	92.3	(11.0)	89.4
	Сул коксжих нүүрс	\$/тонн	69.2	84.8	15.6	122.5
	Сул коксжих нүүрс /Хуурай баяжмал/	\$/тонн	104.6	-	(104.6)	-
	Исэлдсэн, эрчим хүчний нүүрс	\$/тонн	33.9	33.5	(0.3)	98.8
	<b>Хүргэж өгөх нөхцөлөөр</b>	<b>\$/тонн</b>	<b>131.9</b>	<b>117.7</b>	<b>(14.2)</b>	<b>89.2</b>
	Хатуу коксжих нүүрс	\$/тонн	155.2	145.5	(9.7)	93.8
	Сул коксжих нүүрс	\$/тонн	110.9	100.8	(10.1)	90.9
	Исэлдсэн, эрчим хүчний нүүрс	\$/тонн	67.3	65.3	(2.0)	97.0
	Уулын цул	мян.м3	158,900.0	102,666.4	(56,233.6)	64.6
	Хөрс хуулалт	мян.м3	138,900.0	82,505.0	(56,395.0)	59.4
	Нүүрс олборлолт	мян.тн	28,000.0	28,226.0	226.0	100.8
	Хөрс хуулалтын коэффициент	м3/тн	5.0	2.9	(2.0)	58.0
<b>2</b>	<b>Нийт орлого</b>	<b>мян.₮</b>	<b>11,124,212,565.2</b>	<b>9,683,145,405.6</b>	<b>(1,441,067,159.6)</b>	<b>87.0</b>
	Үүнээс: цэвэр борлуулалт	мян.₮	11,103,502,717.6	9,547,902,886.5	(1,555,599,831.1)	86.0
<b>3</b>	<b>Нийт зардал</b>	<b>мян.₮</b>	<b>6,301,450,943.7</b>	<b>4,650,976,946.8</b>	<b>(1,650,473,996.9)</b>	<b>73.8</b>
	<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>мян.₮</b>	<b>6,249,550,801.5</b>	<b>4,640,614,318.4</b>	<b>(1,608,936,483.1)</b>	<b>74.3</b>
	Борлуулсан бүтээгдэхүүний өтрөг	мян.₮	2,636,281,745.9	2,153,348,581.5	(482,933,164.3)	81.7
	Борлуулалт, тээвэр, логистикийн зардал /АМНАТ багтсан/	мян.₮	3,324,925,661.2	2,223,690,324.3	(1,101,235,336.9)	66.9
	Ерөнхий ба удирдлагын зардал	мян.₮	218,249,631.1	187,552,560.4	(30,697,070.6)	85.9
	Хайгуул үнэлгээ, судалгаа хөгжүүлэлтийн зардал	мян.₮	3,339,500.0	841,848.6	(2,497,651.4)	25.2
	Санхүүгийн зардал	мян.₮	66,754,263.4	75,181,003.5	8,426,740.1	112.6
	<b>Үйл ажиллагааны бус зардал</b>	<b>мян.₮</b>	<b>51,900,142.2</b>	<b>10,362,628.4</b>	<b>(41,537,513.8)</b>	<b>20.0</b>
	Нийгмийн хариуцлагын зардал	мян.₮	47,852,799.9	6,220,713.1	(41,632,086.7)	13.0
	Үйл ажиллагааны бус зардал	мян.₮	4,047,342.4	4,141,915.3	94,572.9	102.0
<b>4</b>	<b>Бусад зардал</b>	<b>мян.₮</b>	<b>-</b>	<b>283,859,064.3</b>	<b>283,859,064.3</b>	
	Хүү торгууль хөнгөлөлтийн зардал	мян.₮	-	34,086.8	34,086.8	
	Бондыг эргэлтээс гаргалтын гарз	мян.₮	-	9,273.0	9,273.0	
	Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийн үнэлгээний тохируулгын хэрэгжээгүй гарз	мян.₮	-	172,587,322.6	172,587,322.6	

	Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийн хүүгийн зардал	мян.₮	-	71,335,411.3	71,335,411.3	
	Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын зардал	мян.₮	-	732,387.6	732,387.6	
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	мян.₮	-	(39,160,583.1)	(39,160,583.1)	
<b>5</b>	<b>ААНОАТ-ын зардал</b>	мян.₮	<b>1,204,790,405.4</b>	<b>1,220,583,453.9</b>	<b>15,793,048.5</b>	<b>101.3</b>
<b>6</b>	<b>Цэвэр ашиг</b>	мян.₮	<b>3,617,971,216.1</b>	<b>3,527,725,940.5</b>	<b>(90,245,275.6)</b>	<b>97.5</b>
<b>7</b>	<b>Улсын төсөвт төвлөрүүлэх татвар, хураамжийн ногдол</b>	мян.₮	<b>3,146,295,540.3</b>	<b>3,098,603,515.7</b>	<b>(47,692,024.6)</b>	<b>98.5</b>
<b>8</b>	<b>Хөрөнгө оруулалтын төсөв</b>	мян.₮	<b>8,991,506,009.8</b>	<b>8,991,506,009.8</b>	<b>-</b>	<b>100.0</b>
	2023 онд санхүүжигдэх хөрөнгө оруулалт	мян.₮	2,780,870,991.7	2,296,186,760.0	(484,684,231.7)	83.6

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 906,273.2 сая төгрөгийн 7 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 10,285.0 сая төгрөгийн 12 зөрчил илэрснээс, хариуцлага тооцох 1 албан шаардлага, 10,285.0 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 10,285.0 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

№	Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/							
		Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан		Залруулагүй	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Урт хугацаат авлагын дансанд бүртгэлтэй нэр бүхий 7 байгууллагын 2017-2023 онуудад үүсэж, тооцоо нийлж актаар баталгаажуулсан нийт 2,844,195.4 сая төгрөгийн авлагын үнэ цэнийн бууралтыг санхүүгийн тодруулга тайланд тодруулаагүй, 2,002,947.9 сая төгрөгөөр тайлагнасан байна.	1	841,247,531.3	1	841,247,531.3	1	841,247,531.3		
2	Нүүрс борлуулалтын авлагаас 895.5 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц үүсэхдээ компани тус бүрээр бүртгээгүй "Эрдэнэс Тавантолгой" ХК гэж бөөн дүнгээр тайлагнасан.	1	895,537.8	1	895,537.8	1	895,537.8		
3	Хэрэгжүүлж буй төслүүдийн хүрээнд гарсан цалин, судалгаа шинжилгээний гэх мэт ажил гүйлгээг Дуусаагүй барилга, байгууламж болон дуусаагүй үйлдвэрлэлд хуримтлуулан бүртгээгүй, урьдчилж гарсан зардал, урьдчилж төлсөн төлбөрөөр бүртгэж тайлагнасан байна.	1	8,021,961.8	1	8,021,961.8	1	8,021,961.8		
4	Өмнөх онуудад гүйцэтгэсэн 10 ажлын судалгаа шинжилгээ, техник эдийн засгийн үзүүлэлтийн баримт бичгүүдийг урьдчилж гарсан зардлаар бүртгэж, тайлант онд нийт 60.6 сая төгрөгийн хорогдуулалт тооцон зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.	1	60,592.7	1	60,592.7	1	60,592.7		
5	Урьдчилж төлсөн төлбөр дансанд шүүхийн шийдвэрээр Чингис хаан банкнаас авах 266.5 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн авлагыг данс зөрүүтэй бүртгэсэн.	1	266,500.0	1	266,500.0	1	266,500.0		
6	Тайлант оны эхний хагас жилийн байдлаар 96 харилцагчтай үүссэн 55,777.4 сая төгрөгийн урьдчилж төлсөн төлбөр тооцоог урьдчилж гарсан зардлаар данс зөрүүтэй бүртгэсэн байна.	1	55,777,400.0	1	55,777,400.0	1	55,777,400.0		
7	Оны эхний хангамжийн материалын үлдэгдэлд 3 нэр төрлийн 9 ширхэг 3.7 сая төгрөгийн материалыг хасах тэмдэгтэй бүртгэж тайлагнасан.	1	3,720.0	1	3,720.0	1	3,720.0		
	<b>Дүн</b>	<b>7</b>	<b>906,273,243.64</b>	<b>7</b>	<b>906,273,243.64</b>	<b>7</b>	<b>906,273,243.64</b>		

Аудитаар нийт 10,285.0 сая төгрөгийн 12 зөрчил илэрснээс, хариуцлага тооцох 1 албан шаардлага, 10,285 0 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Тухайн байгууллагын ашиглаж буй санхүүгийн программ нь Сангийн яамны зөвшөөрөлтэй санхүүгийн программ хангамжийн жагсаалтад бүртгэлгүй, журнал, дэлгэрэнгүй бүртгэлүүд нь баталсан маягт загвараар гардаггүй.	1				1			
2	Тус байгууллага 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаа 5 хоног хоцроож ирүүлэхдээ санхүүгийн тайлангийн тодруулга, толилуулгад нэмэлт тайлбар, тэмдэглэл хийгээгүй.	1		1					
3	Санхүүгийн тайланд тусгагдсан 6,444.3 сая төгрөгийн өглөг, 244.5 сая төгрөгийн авлагыг тус тус тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна	1	6,688,828.1	1	6,688,828.1				
4	Тус байгууллага "Бахархалт тээвэрчид" ХХК -тай 2022 онд ЭТТ-2022/772, ЭТТ-2022/773 дугаар бүхий "20,000 тонн нүүрс худалдах, худалдан авах" гэрээ байгуулан, гэрээний дагуу урьдчилгаа төлбөр төлсөн тохиолдолд ачилт хийх заалтыг зөрчиж, 19,997.8 тонн нүүрс нийлүүлсэн. Тайлант оны эцэст 6,969.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэлд гэрээнд заасны дагуу гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс 3,484.7 сая төгрөгийн алданги тооцоогүй байна.	1	3,484,778.4	1	3,484,778.4				
5	Өмнөговь аймгийн Онцгой байдлын газар, Даланзадгад хотын дулааны цахилгаан станц, Хилийн цэргийн 0131-р анги, Тавантолгой түлш, Тавантолгой төмөр зам, Моннис Майнинг ХХК, Цанхи хотхон, Грийн центр, Эрдэнэс нэгдсэн терминал цогцолбор зэрэг дотоодын байгууллагуудад нийлүүлсэн нийт 29,363.8 тн нүүрс ачааны автомашины жин, тоннд хяналт тавих пүүний програмд бүртгэгдээгүй.	1				1			
6	Эрдэнэс Тавантолгой ХК-ны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн "Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг хангах тухай" 36 тоот тогтоолоор "Даланзадгадын дулааны цахилгаан станц" ТӨХК-д нийгмийн хариуцлагын хүрээнд 18,291.55 тн нүүрс нийлүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна.	1				1			

7	Ажлын тусгай хувцас, хамгаалах тусгай хэрэгслийн хөдөлгөөн, зарцуулалтад нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт сул, өөрсдийн саналаар болон ажлын хариуцлагаас шалтгаалан ажлаас гарсан ажилчдын хувцас, хэрэгслийн тооцоо хийх зохицуулалт байхгүй байна.	1				1			
8	Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 14-40 жилийн хугацаатай 65 газар эзэмших эрх бүхий 10,493.4 га газрыг анхны өртгөөр нь үнэлж бүртгээгүй байна.	1				1			
9	Тус компани нь гэрээ хэлцэл хийгээгүй, менежментийн үйлчилгээ аваагүй байхад "Эрдэнэс Монгол" ХХК-нд 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдөр 20,000.0 сая төгрөгийг "менежментийн урьдчилгаа" гэж шилжүүлсэн. "Эрдэнэс Монгол" ХХК -тай 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр ЭМГЛ-63/МГ-05/20230623, ЭТТ-2023/1533 дугаартай "Менежментийн үйлчилгээ үзүүлэх" 180,987.1 сая төгрөгийн гэрээ байгуулж, тухайн өдөртөө 160,987.1 сая төгрөгийг "менежментийн төлбөр"-т шилжүүлсэн байна.	1				1			
10	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 9,398.2 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 179,593.4 сая төгрөгийн 9 зөрчилд 9 албан шаардлага хүргүүлснээс 1,351.1 сая төгрөгийн 5 албан шаардлагыг хэрэгжүүлж, 2 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. (9,398.2 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 2 албан шаардлагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж шийдвэр гараагүй байна)	1						1	
11	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжөөс 642,458.7 сая төгрөгийн 6 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна	1		1					
12	Байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамааралгүй зарим орон тоог давхардуулан гэрээт ажилтан авч ажиллуулан 111.4 сая төгрөгийн үргүй зардал гаргасан байна.	1	111,411.6	1	111,411.6				
<b>Дүн</b>		<b>12</b>	<b>10,285,018.1</b>	<b>5</b>	<b>10,285,018.1</b>	<b>6</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 3 зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн.

#### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал

№	Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/ Үүнээс					
		Нийт зөрчил		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
1	Эрдэнэс Тавантолгой ХК-ийн газар, хэлтэс, албаны ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг түүвэрлэн шалгахад зарим газар, хэлтсийн удирдах албан тушаалтнуудын үндсэн чиг үүрэг, зорилго нь харьяалагдах нэгжийн	1				1	

	албан тушаалтнуудынхтай давхардсан, өөр чиг үүрэгтэй газар, хэлтэс, албаны ажилтнуудын үндсэн чиг үүрэг, зорилго хоорондоо ижил, зарим албан тушаалтнуудын үндсэн чиг үүрэг, зорилго нь тодорхой биш байна.					
2	Тус байгууллагын уурхайн салбарт орон тоогоор 878 ажилтан албан хаагчид ажиллаж байхад цалин хариуцсан нягтлан бодогчгүй байна.	1			1	
3	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хамтын гэрээний дараах заалтууд Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нийцээгүй байна. Үүнд: - Хамтын гэрээний 3.3.1 "Тухайн жилийн ажлын үр дүнгийн урамшууллыг нийт ажилтанд тухайн жилд ажилласан хугацааг харгалзан 4-6 сарын компанийн дундаж цалинтай тэнцүү хэмжээгээр тооцон жил бүрийн 1 дүгээр сард багтаан олгоно", 3.3.3-д "байдлыг харгалзан Гүйцэтгэх захирлын тушаалаар нийт ажилтнуудад 13 дах сарын шагналт цалинг жил бүр олгоно" гэж тус тус заасан нь Хөдөлмөрийн тухай хуультай нийцэхгүй байна.	1			1	
	Дүн	3			3	

# ХОЁРДУГААР БҮЛЭГ

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/34/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2024 он	Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Д.Энхболд Утас: 263753 Цахим <a href="mailto:enkhboldd@audit.gov.mn">хаяг:enkhboldd@audit.gov.mn</a> ГНАГ-ын аудитын менежер: Б.Саруул Утас: 261605 Цахим <a href="mailto:saruulb@audit.gov.mn">хаяг:saruulb@audit.gov.mn</a> ГНАГ-ын ахлах аудитор Б.Батдэлгэр Утас: 261675 Цахим <a href="mailto:Batdelgerb@audit.gov.mn">хаяг:Batdelgerb@audit.gov.mn</a> ГНАГ-ын ахлах аудитор М.Сангиганцан Утас: 261675 Цахим хаяг: <a href="mailto:Sangijantsanm@audit.gov.mn">Sangijantsanm@audit.gov.mn</a> ГНАГ-ын аудитор:Л.Гансүх Утас: 261675 Цахим хаяг: <a href="mailto:Gansukhl@audit.gov.mn">Gansukhl@audit.gov.mn</a> ГНАГ-ын аудитор: О.Дашхонгор Утас: 261675 Цахим хаяг: <a href="mailto:Dashhongoro@audit.gov.mn">Dashhongoro@audit.gov.mn</a> ГНАГ-ын аудитор: Ж.Чинбат Утас: 261675 Цахим хаяг: <a href="mailto:Chinbat@audit.gov.mn">Chinbat@audit.gov.mn</a> ГНАГ-ын аудитор: Х.Шинэбаяр Утас: 261675 Цахим хаяг: <a href="mailto:Shinebayar.kh@audit.gov.mn">Shinebayar.kh@audit.gov.mn</a>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Гүйцэтгэл-нийцлийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Аудитаар нийт 14 зөрчил илэрснээс, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх 3 зөвлөмж , 1 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 10 зөвлөмж өгсөн.

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Албан шаардлага		Зөвлөмж		Хууль хяналтын байгууллагад	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
1	Нүүрс тээврийн зориулалтаар импортлож буй автомашины илүүдлээс автомашины бүтээмж буурч, сул зогсолт нэмэгдэж, банк, банк бус санхүүгийн байгууллагаас зээлээр авсан иргэн, ААНБ-ын зээлийн эргэн төлөлт эрсдэлд орохоор байна.	1				1			
2	Сая тонн-Сая мод хөтөлбөрийн хүрээнд байгуулсан гэрээний хэрэгжилтэд байгууллагын дотоод хяналт тавиагүй, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ аваагүй нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хэрэгжилт хангагдахгүй байх эрсдэлийг бий болгож байна.	1				1			
3	Нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн бүтээн байгуулалтад тавих захиалагчийн хяналтад мэргэжлийн зөвлөх хуулийн этгээдийг ажиллуулаагүй нь тухайн төслийн үйл ажиллагаа холбогдох стандартын дагуу чанартай гүйцэтгэсэн эсэхийг үнэлэх бололцоогүй эрсдэлийг үүсгэж байна.	1				1			
4	Хууль зөрчиж, олгосон санхүүжилтийг төсөвлөгдөөгүй зардалд хэлцэл хийж, гэрээ байгуулан үргүй зарцуулсан зөрчлийг Төрийн өмчит компанийн удирдлагууд удаа дараа гаргаж байгаа тул хууль тогтоомжид заасны дагуу хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгах арга хэмжээ авч үргүй зардал гарахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай байна.	1				1			
5	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн санхүүжүүлсэн төмөр замын төслүүд нь техник, эдийн засгийн үндэслэлд туссан ачааг тээвэрлэж чадахгүй байна.	1				1			
6	ОБЕГ-тай 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдөр 28,045.8 сая төгрөгийн дүнтэй ЭТТ-2022/503 дугаар хамтран ажиллах гэрээ байгуулж 27,500.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч гэрээний үүргийн хэрэгжилт өнөөдрийг хүртэл хангагдаагүй, нэг ч модны үрсэлгээг хийгээгүй байна.	1				1			
7	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй, хэрэгжсэн гэх төслүүд нь техник эдийн засгийн үндэслэлд туссан үр ашгаа өгөхгүй байгаагаас компанид болон улс, орон нутагт үр нөлөөгөө өгсөн төсөл, хөтөлбөр байхгүй байна	1				1			
8	Уурхайн олборлолтод ТЭЗҮ-д тусгаагүй олон төрөл, тооны техникүүдийг нэгдсэн байдлаар удирдан хянах диспетчерийн программ хангамжийн тогтолцоо бүрдүүлээгүй, Кибер аюулгүй байдлын тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.	1				1			

9	ХАА-ны 2023 оны төлөвлөгөөний биелэлт 65.3 хувьтай буюу “хангалтгүй” байгаа нь хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүй, төлөвлөгөөнд олон удаа өөрчлөлт оруулж төсөвт өртөг, хэрэгжүүлэх хугацааг бодит бусаар төлөвлөснөөс шалтгаалсан байна	1				1			
10	ҮСА-уурхайн ам нөхцөлтэй борлуулагдаж буй нүүрсийг худалдан авагчийн нэрлэсэн тээврийн хэрэгсэлд ачуулснаас хойш дахин дээж авч, үргүй зардал гаргаж байна.	1				1			
11	Богдхан төслийн хүрээнд Тавантолгой төмөр зам ХХК-ийн байгуулсан дээрх гэрээнүүдийн дагуу зарцуулсан зарцуулалтын ИРС буюу ажлын гүйцэтгэлийн тайлан өнөөдрийг хүртэл баталгаажгаагүй байна.	1		1					
12	ШӨХТГ-аас Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн худалдан авалттай холбоотой байгуулагдсан үнэлгээний хороонд албан бичиг удаа дараа хүргүүлж, тендер шалгаруулалтын хугацааг хойшлуулах, тендерийн жишиг баримт бичгийг өөрчлүүлэх зэргээр нөлөөлж техникийн тодорхойлолтод заасан барааг нийлүүлэх, ажлыг гүйцэтгэх чадваргүй, туршлагагүй, санхүүгийн чадамжгүй, гүйцэтгэгч шалгарах нөхцөлийг бүрдүүлсэн байна	1						1	
13	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн эргэн төлөгдөх нөхцөлтэй урт хугацаатай ЭТТ-2022/83, ЭТТ-2022/502, ЭТТ-2022/518 дугаартай гэрээгээр авсан санхүүжилтүүдийг Тавантолгой түлш ХХК нь хууль, норм дүрэмд заасан шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнд, зарим мөнгөн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах шийдвэр гарган албан тушаалын байдлаа хэтрүүлж, улсад их хэмжээний хохирол үүсгэсэн байх магадлалтай гэж үзээд хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахаар шийдвэрлэв.	1						1	
14	Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн эргэн төлөгдөх нөхцөлтэй урт хугацаатай ЭТТ-2022/83, ЭТТ-2022/502, ЭТТ-2022/518 дугаартай гэрээгээр авсан санхүүжилтүүдийг Тавантолгой түлш ХХК нь хууль, норм дүрэмд заасан шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнд, зарим мөнгөн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах шийдвэр гарган албан тушаалын байдлаа хэтрүүлж, улсад их хэмжээний хохирол үүсгэсэн байх магадлалтай гэж үзээд хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахаар шийдвэрлэв.	1						1	
	Дүн	14		1		10		3	